

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ**

**Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6, 29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны A/82 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Шинжээч сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах” журмын зарим хэсэг, заалтад дор дурдсан нэмэлт, өөрчлөлт оруулсугай:

2.1. "...Үндэсний аудитын газрын Тамгын газарт хүргүүлэх бөгөөд Тамгын газар төлөвлөгөө боловсруулан..." гэснийг "...Үндэсний аудитын газрын Захиргаа, удирдлагын газарт хүргүүлэх бөгөөд тус газар нь төлөвлөгөө боловсруулан, Тамгын даргаар хянуулж" ... гэж.

6.3. "...Тамгын газар" гэснийг "...Захиргаа, удирдлагын газар..." гэж.

2. Журмын 3 дугаар зүйлийн 3.1, 3.4.1, 3.4.2 дахь заалтад “10 сая” гэснийг “20 сая” гэж, 3.4.1.2, 3.4.2.1-д “...5 хоног...” гэснийг “ажлын 5 хоног...” гэж нэмж өөрчилсүгэй.

3. Журмын 4 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

4.1.“Сонгон шалгаруулалтад оролцогч этгээдийн ирүүлсэн санал нь санал хүлээн авахаар товлосон өдрөөс 30 хоногийн хугацаанд хүчинтэй байх ба уг хугацаанд багтан гэрээ байгуулна”.

4. Журмын 4 дүгээр зүйлд нэмэлт заалт орсондой холбогдуулан 4 дүгээр зүйлийн 4.1 дэх заалтыг 4.2 гэж, 4.2 дахь заалтын “Монгол Улсын Ерөнхий аудитор” гэсний дараа “эсвэл түүний эрх олгосон албан тушаалтан” гэж нэмж, “4.2” гэснийг “4.3” гэж, “4.3” гэснийг “4.4” гэж, “4.4” гэснийг “4.5” гэж, “4.5” гэснийг “4.6” гэж, “4.6” гэснийг “4.7” гэж, “4.7” гэснийг “4.8” гэж дэс дугаарлалтыг тус тус өөрчилсүгэй.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар /Ш.Үнэнтөгс/-т даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

**Д.ЗАНДАНБАТ**

## ТАНИЛЦУУЛГА

2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр

Журамд нэмэлт, өөрчлөлт  
оруулах тухай

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/82 дугаар тушаалаар батлагдсан “Шинжээч сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах” журам Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдэн хэрэгжиж байна.

Тус журмын хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/31 дүгээр тушаалаар “Төрийн аудитын байгууллагын 2021 онд аудитад шинжээч оролцуулах үйл ажиллагааны төлөвлөгөө” батлагдаж, төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллалаа. Үүнд: Захиргаа, удирдлагын газар шинжээч сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтийг хянах, санхүүжилт, төлбөр тооцоо хийх үйл ажиллагааг зохион байгуулж, захиалагч нэгж нь шинжээчийн ажлын тайлан, дүгнэлтийг хүлээн авч, гүйцэтгэлийг үнэлэн, гэрээ дүгнэн, акт үйлдэн, баталгаажуулах үйл ажиллагааг тус тус зохион байгуулсан.

Журмын хэрэгжилтийн явцад “Босго үнэ шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол гарч, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах зөвлөх үйлчилгээний босго үнэ “Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар 20.0 сая төгрөг” гэж өөрчлөгдсөн.

Мөн Үндэсний аудитын газрын бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй уялдан журамд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага үүсээд байна. Үүнд:

1. Журамд, сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт хүлээн авах болон дэлгэрэнгүй жагсаалтад бүртгэх хугацааг зар нийтэлснээс хойш **5 хоног** байна гэж заасан ба сонгон шалгаруулалтын өрсөлдөх тэгш боломжтой байх зарчмыг баримтлан 3 дугаар бүлгийн 3.4.1.2 болон 3.4.2.1 дэх заалтад тус бүр “**ажлын**” гэж нэмэлт оруулах;
2. Сонгон шалгаруулалтад оролцогчийн саналын хүчинтэй хугацаа болон уг хугацаанд багтаж гэрээ байгуулах агуулгыг журамд тусгаагүй тул 4 дүгээр зүйлд “**Сонгон шалгаруулалтад оролцогч этгээдийн ирүүлсэн санал нь санал хүлээн авахаар товлосон өдрөөс 30 хоногийн хугацаанд хүчинтэй байх ба уг хугацаанд багтан гэрээ байгуулна**” гэж заалт нэмж оруулах;
3. Журмын 4 дүгээр зүйлийн 4.2-т “Гэрээг захиалагчийг төлөөлж, Үндэсний аудитын газарт Монгол Улсын Ерөнхий аудитор, эсвэл түүний эрх олгосон албан тушаалтан...” батална гэж нэмэлт оруулах;
4. Журмын 4 дүгээр зүйлд нэмэлт заалт орж буйтай холбогдон заалтын дугаарыг өөрчлөх.

Хянасан: Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Д.Наранцэцэг

Хууль эрх зүйн менежер

Б.Баттогтох

Боловсруулсан: Худалдан авах үйл ажиллагаа хариуцсан шинжээч Н.Цэнд-Аюуш

**ЖУРАМД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ САНАЛЫН ТОВЬЁОГ**

2021 оны 12 дугаар сарын 24-ний өдөр

Улаанбаатар хот

	<p>Д/д Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/82 дугаар тушаалаар батлагдсан “Шинжээч сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах” журмын холбогдох заалт:</p> <p align="center"><b>ХОЁР. ШИНЖЭЭЧИД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА БОЛОН СОНГОН ШАЛГАРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ</b></p>	<p>Нэмэлт, өөрчлөлт оруулах санал:</p>
1	<p>2.1. Төрийн аудитын байгууллагын бүтцийн нэгж нь тухайн жилд гүйцэтгэх аудитын болон жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан энэ журмын 1.4.3-т зааснаас бусад шинжээчийг аудитад оролцуулах саналыг төсвийн тооцооллын хамт жил бүрийн 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Үндэсний аудитын газрын Тамгын газарт хүргүүлэх бөгөөд Тамгын газар төлөвлөгөө боловсруулан Монгол Улсын Ерөнхий аудитораар 2 дугаар сарын 01-ний өдрийн дотор батлуулна.</p>	<p>2.1. Төрийн аудитын байгууллагын бүтцийн нэгж нь тухайн жилд гүйцэтгэх аудитын болон жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан энэ журмын 1.4.3-т зааснаас бусад шинжээчийг аудитад оролцуулах саналыг төсвийн тооцооллын хамт жил бүрийн 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Үндэсний аудитын газрын <u>Захиргаа, Удирдлагын газарт хүргүүлэх бөгөөд тус газар нь төлөвлөгөө боловсруулан, Тамгын даргаар хянуулж,</u> Монгол Улсын Ерөнхий аудитораар 2 дугаар сарын 01-ний өдрийн дотор батлуулна.</p>
2	<p align="center"><b>ГУРАВ. ШИНЖЭЭЧ СОНГОН ШАЛГАРУУЛАХ</b></p> <p>3.1. Төсөвт өртөг нь 10 сая төгрөг хүртэлх ажлын шинжээч сонгон шалгаруулалтыг Үндэсний аудитын газар болон аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын худалдан авах ажиллагаа хариуцсан бүтцийн нэгж (хариуцсан ажилтан), 10 сая төгрөгөөс дээш төсөвт өртөг бүхий ажлын шинжээчийг энэ журмын 3.2 дахь хэсэгт заасан ажлын хэсэг захиалагч нэгжээс ирүүлсэн ажлын даалгаврыг үндэслэн зохион байгуулна.</p>	<p>3.1. Төсөвт өртөг нь <u>20 сая</u> төгрөг хүртэлх ажлын шинжээч сонгон шалгаруулалтыг Үндэсний аудитын газар болон аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын худалдан авах ажиллагаа хариуцсан бүтцийн нэгж (хариуцсан ажилтан), <u>20 сая</u> төгрөгөөс дээш төсөвт өртөг бүхий ажлын шинжээчийг энэ журмын 3.2 дахь хэсэгт заасан ажлын хэсэг захиалагч нэгжээс ирүүлсэн ажлын даалгаврыг үндэслэн зохион байгуулна.</p>
3	<p>3.4. Худалдан авах ажиллагаа хариуцсан бүтцийн нэгж (хариуцсан ажилтан) болон ажлын хэсэг дараах үе шатны дагуу шинжээчийг сонгон шалгаруулна:</p> <p align="center"><b>3.4.1. Төсөвт өртөг нь 10 сая төгрөг хүртэлх ажлын шинжээч сонгон шалгаруулах:</b></p> <p>3.4.1.2. оролцогч нь захиалагчийн зарлал болон урилгад дурдсан шаардлагын дагуу саналаа боловсруулах бөгөөд оролцох хүсэлт хүлээн авах хугацаа зар нийтэлснээс хойш 5 хоног байна. Уг хугацаа дуусмагц хүсэлт ирүүлсэн этгээдийн бүртгэлийг хөтөлж, баримтжуулна.</p>	<p>3.4. Худалдан авах ажиллагаа хариуцсан бүтцийн нэгж (хариуцсан ажилтан) болон ажлын хэсэг дараах үе шатны дагуу шинжээчийг сонгон шалгаруулна:</p> <p align="center"><b>3.4.1. Төсөвт өртөг нь <u>20 сая</u> төгрөг хүртэлх ажлын шинжээч сонгон шалгаруулах:</b></p> <p>3.4.1.2. оролцогч нь захиалагчийн зарлал болон урилгад дурдсан шаардлагын дагуу саналаа боловсруулах бөгөөд оролцох хүсэлт хүлээн авах хугацаа зар нийтэлснээс хойш <u>5 хоног</u> байна. Уг хугацаа дуусмагц хүсэлт ирүүлсэн этгээдийн бүртгэлийг хөтөлж, баримтжуулна.</p>

4	<b>3.4.2. Төсөөт өртөг нь 10 сая төгрөгөөс дээш ажлын шинжээч сонгон шалгаруулах:</b>  3.4.2.1. ажлын хэсэг шинжээч сонгон шалгаруулах дэлгэрэнгүй жагсаалтад бүртгэх тухай зар (шинжээчид тавигдах шаардлага, материал ирүүлэх хугацаа, төсөөв бүхий)-ыг өдөр тутмын хэвлэл, байгууллагын цахим хуудсаар олон нийтэд мэдээлнэ. Дэлгэрэнгүй жагсаалтад бүртгэх хугацаа зар нийтэлснээс хойш 5 хоног байх бөгөөд хугацаа дуусмагц хүсэлт ирүүлсэн этгээдийн бүртгэлийг хөтөлж, баримтжуулна.	<b>3.4.2. Төсөөт өртөг нь 20 сая төгрөгөөс дээш ажлын шинжээч сонгон шалгаруулах:</b>  3.4.2.1. ажлын хэсэг шинжээч сонгон шалгаруулах дэлгэрэнгүй жагсаалтад бүртгэх тухай зар (шинжээчид тавигдах шаардлага, материал ирүүлэх хугацаа, төсөөв бүхий)-ыг өдөр тутмын хэвлэл, байгууллагын цахим хуудсаар олон нийтэд мэдээлнэ. Дэлгэрэнгүй жагсаалтад бүртгэх хугацаа зар нийтэлснээс хойш <u>ажлын 5 хоног</u> байх бөгөөд хугацаа дуусмагц хүсэлт ирүүлсэн этгээдийн бүртгэлийг хөтөлж, баримтжуулна.
<b>ДӨРӨВ. ШИНЖЭЭЧТЭЙ ГЭРЭЭ БАЙГУУЛАХ</b>		
5		4.1. Сонгон шалгаруулалтад оролцогч этгээдийн ирүүлсэн санал нь санал хүлээн авахаар товлосон өдрөөс 30 хоногийн хугацаанд хүчинтэй байх ба уг хугацаанд багтан гэрээ байгуулна.
6	4.1.	4.2.
7	4.2. Гэрээг захиалагчийг төлөөлж, Үндэсний аудитын газарт Монгол Улсын Ерөнхий аудитор, аймаг нийслэл дэх Төрийн аудитын газарт тэргүүлэх аудитор батална.  Шинжээч болон шалгагдагч этгээдийг эрх бүхий этгээд төлөөлж, гэрээг батална.	4.3. Гэрээг захиалагчийг төлөөлж, Үндэсний аудитын газарт Монгол Улсын Ерөнхий аудитор, <u>эсвэл түүний эрх олгосон албан тушаалтан</u> , аймаг нийслэл дэх Төрийн аудитын газарт тэргүүлэх аудитор батална.  Шинжээч болон шалгагдагч этгээдийг эрх бүхий этгээд төлөөлж, гэрээг батална.
	4.3	4.4.
	4.4	4.5.
	4.5.	4.6.
	4.6	4.7
	4.7	4.8
<b>ЗУРГАА. ШИНЖЭЭЧТЭЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭГ ДҮГНЭХ</b>		
8	6.3. Захиалагч нэгж шинжээчийн ажлын гүйцэтгэлийг үнэлж, гэрээг дүгнэсэн акт үйлдэн, тайлан, дүгнэлтийн хамт Үндэсний аудитын газрын Тамгын газар, аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын Тэргүүлэх аудиторт тухай бүр хүргүүлэх бөгөөд гүйцэтгэлийн үнэлгээнээс хамаарч, гэрээнд заасны дагуу ажлын хөлсийг олгоно.	6.3. Захиалагч нэгж шинжээчийн ажлын гүйцэтгэлийг үнэлж, гэрээг дүгнэсэн акт үйлдэн, тайлан, дүгнэлтийн хамт Үндэсний аудитын газрын <u>Захиргаа, удирдлагын газар</u> , аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын Тэргүүлэх аудиторт тухай бүр хүргүүлэх бөгөөд гүйцэтгэлийн үнэлгээнээс хамаарч, гэрээнд заасны дагуу ажлын хөлсийг олгоно.